

## ХОТЫН СОЦИОЛОГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ БА СЕГРЕГАЦИЙН АСУУДАЛ

*Т.Бүрэнжаргал доктор, проф*  
*МУИС, ШУС, Социологи, нийгмийн ажлын тэнхим*  
*Orcid:0000-0002-0692-1885*  
*Ё.Ундрал МУИС, ШУС*  
*Социологи, нийгмийн ажлын тэнхимийн докторант*

**Abstract:** *The aim of article is to explain the theory and concept of urban sociology and to determine the signs of urban segregation. M. Weber, G. Simmel, E. Durkheim and F. Tönnis laid the foundations of urban sociology. But the researchers of the Chicago School developed theories, concepts and methods of urban sociology. Urban segregation occurs gradually in large cities and is characterized by geographically pronounced social stratification and social inequality.*

**Keywords:** *Urban sociology, social segregation, chicago school theory*

### Оршил

Дэлхийд 2008 оноос хойш хүн төрлөхтний түүхэнд анх удаа хүн амын талаас илүү хувь нь хотод амьдарч байна (UN, 2008). НҮБ-ын 2006 оны хэтийн тооцоогоор 2030 онд хотын хүн ам дэлхийн хүн амын 60 хувийг эзлэх болно.

Монгол Улсад хот суурин бий болж хотжилтын үйл явц сүүлийн 10 жилд эрчимтэй явагдаж байгаа. Монгол Улс 1990 оноос зах зээлийн системд шилжиж эхлээд 30 гаруй жил болж байна. Энэ нь нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн хувьд өөрчлөлтүүдийг дагуулж ирсэн. Мөн хамгийн гол өөрчлөлт нь баян хоосны ялгаа, хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн болон хотжих үйл явц. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод Монгол Улсын хүн амын бараг тал хувь нь амьдарч байна. Тиймээс хотын орон зайд баян, дунд болон доод амьжиргааны түвшний бүлгүүд хотод хэрхэн тархсан, энэ нь нийгмийн тэгш бус байдал болон нийгмийн давхраажлыг хэрхэн илэрхийлж байгааг судлах шаардлагатайг илэрхийлж байна.

### Хотын социологийн үүсэл, хөгжил, онолын үндэс

Хотын социологийн үүслийг М.Вебер, Р.Парк, Л.Вирт, Э.Берджесс зэрэг эрдэмтдийн бүтээлүүд тавьсан. Ф.Теннис, Э.Дюркгейм, Г.Зиммельээс үүсэлтэй бөгөөд тэдний санаанууд Чикаго сургуулийн үзэл баримтлалын суурь болсон.

Макс Вебер “Хот” гэсэн бүтээлдээ дундад зууны хотын гол шинжийг нэрлэж тайлбарласан байдаг. “Хотын байшингууд хоорондоо нягт байрладаг боловч оршин суугчид нь бие биенээ мэддэггүй том суурин газар гэж тодорхойлсон. Үүнээс үзэхэд хүн ам ихтэй суурин газар болгоныг хот гэж нэрлэхгүй агаад хүн амын тоо суурь шалгуур болохгүй юм. ... Хотын шинж чанарууд нь: а) Бэхлэлт бэхлэгээ; б) Зах худалдааны төвүүд; в) Хувийн шүүх ба хотын иргэдийн нэгдлийн эрх, эрх чөлөө; г) Нэгдмэл чанар ба хараат бус байдал зэрэг юм.” (ШУА, 2014)

Чикаго сургуулийн хөгжилд Г.Зиммелийн санаанууд маш их нөлөөлсөн. Зиммель том хотын оршин суугчийн сэтгэл зүйн шинж тэмдгийг тодорхойлсон байдаг. Тэрээр бичихдээ: “Нягтаршил, шахуу байдал нь сэтгэлийн төсөөрлийг л зөвхөн ялгаруулж байна. Мэдээж тэгэлгүй яахав дээ, том хотуудын шахалдсан газар л өөрийгөө хамгийн ганцаардмал, хаягдсан гэдгээ мэдрэх болно.” (Simmel, 1903)

Ф.Теннис ба Э.Дюркхаймын санаагаар хот нь нийгмийн холбоосын онцгой төрөл юм. Тухайн нийгмийн холбоосыг нийгэм буюу “Gesellschaft” гэж нэрлэж түүний суурь нь рационал солилцоо юм. Харин хөдөө орон нутгийн нийгмийн холбоосыг Теннис “нийгэмлэг” буюу Gemeinschaft гэж нэрлэжээ. Хотын холбоос, зохицуулалтын механизмууд нь нийгмийн субъектийн биеэс тусгаарлагдмал, албан ёсны шинж чанартай. Нийгэмлэг нь соёл, уламжлалыг илүү хадгалж чадсан сэтгэл хөдлөлийн холбоос дээр тулгуурладаг. Нийгэм ба нийгэмлэг нь төгс төрлүүд: бүх хөгжил нь хотын нийгэм рүү ойртож байгаа ч нийгэмлэгийн хүч тод илэрдэггүй ч гэсэн хүчтэй хэвээр үлдэж нийгмийн амьдралын бодит зүйлээр үлддэг. Мөн Зиммелийн дагуу мөнгө ба цаг хоёр

хотын амьдралд хамгийн гол үүргийг гүйцэтгэдэг. Берлины цагууд ганц цагаар ч гэсэн зогсвол юу болохыг хэн ч тааж чадахгүй гэжээ. Энэ нь янз бүрийн гэмт хэрэг, сүйрэлд хүргэдэг. Мөнгө бол бүх нийтийн хөдөлмөрийн хуваарилалтын үеийн солицооны хэрэгсэл байдаг гэжээ (ФСЭХ, 2012).

Хотын социологийн хөгжлийн гол үе нь 1920-1930 онд Чикагогийн социологийн школ үүссэнээр авч үздэг байна. Түүний гол төлөөлөгчид нь Р. Парк, Э. Берджес, Л. Вирт. Тухайн школын манлайлагч, үүсгэн байгуулагч нь Америкийн социологийн холбооны ерөнхийлөгч Роберт Парк гэж тооцогддог. Түүний боловсруулсан хотын экологи нь байгалийн ба нийгмийн шинжлэх ухааны уулзвар дахь шинэ чиглэл болж, түүний эх үүсвэр нь байгаль, нийгмийн нэгдмэл байдлын санаа юм. Энэ нь хотжилт, гэр бүл, нийгэмлэг, хувь хүний нийгэмших байдал, хотын нийгмийн судлалын асуудлуудыг авч үзсэн Э. Берджесын боловсруулсан Чикаго дахь орон нутгийн иргэдийг судлах судалгааны хөтөлбөрийн үндэс болжээ. Түүнчлэн, хотыг "хүний далд хүчийг нээн илрүүлэх, хүний мөн чанар, нийгмийг судлах бүх газраас хамгийн шилдэг нь" гэж үздэг байсан Парк нь нийгмийн орчны нөлөөллийн дүн шинжилгээ болох "Хот бол нийгмийн лаборатори" (1925) бүтээлээрээ алдартай. Р. Парк хотыг "ердийн намтар түүхтэй тусгай байгууллага" гэж тодорхойлсон бөгөөд "нэг хотын талаар олж авсан мэдлэгийг бусад хотуудын хувьд (тодорхой хэмжээгээр) үнэн гэж үзэж болохуйц бие даасан хотууд хангалттай ижил төстэй шинж чанартай байдаг" гэж хэлсэн байдаг. Паркын тэмдэглэсэнээр "хот бол зөвхөн олдвор биш", "харин тодорхой утгаараа организм юм".

Л. Вирт "Хотжилт амьдралын хэв маяг болох нь" бүтээлдээ (1937) хот суурин газрын амьдралын хэв маягийн тодорхойлолтыг боловсруулж, "урбанизм" хэмээх ойлголтыг социологийн эргэлтэд анх нэвтрүүлсэн юм. Теннисийн санааг үргэлжлүүлэн тэрээр хотын оршин суугчдын харилцаа холбоо нь өнгөцхөн, албан ёсны, аноним шинжтэй, хувийн харилцаа холбоо нь тасардаг гэж үздэг. Түүнчлэн, Чикагогийн социологийн школд биологийн шинжлэх ухааныг хүн төрлөхтний хөгжилтэй хослуулж, нийгмийн зохион байгуулалтыг ухамсаргүй хувьслын үр дүн гэж үздэг хотын амьдралыг судлах "хотын экологи" хэмээх хандлага бий болжээ (Р. Парк, Р. Маккензи, Л. Вирт, Э. Берджес и Х. Зорбах). Социаль дарвинизмын хамгийн алдартай уриа лозунг болох "хамгийн хүчтэй нь л амьд үлддэг" гэсэн уриалгыг ашиглан хотын экологийн хандлагаар Чикаго дахь цагаачдын амьдралыг судлав. Төрийн оролцоогүйгээр хотын орон зайг эзлэх тэмцлийн дараа цагаачдын хооронд ийгмийн харилцан үйлчлэлийн үр өгөөжтэй тогтвортой харилцаа тогтоож буюу тогтвортой экологийн тогтолцоо бий болгосон. Янз бүрийн хандлагыг тус тусад нь болон хослуулан ашиглах нь хотын амьдралын хэв маягийг социологийн үүднээс судлах, өнөө үеийн зууны хот байгуулалтын хэтийн төлөвийг тодорхойлох томоохон боломжийг олгодог байна. (Одриосола, 2014)

Дээрх эрдэмтэн судлаачдын бүтээлээс харахад хот бол аж үйлдвэржсэн нийгмийн бүтээгдэхүүн бөгөөд энэ нь оршин суугчдын өвөрмөц сэтгэл зүйн байдал, нийгмийн холбоосын шинэ төрлийг үүсгэсэн байна.

Сегрегацийг үндсэн гурван онолын үзэл баримтлалаар судалдаг.

**Хотыг чиг үүргийн бүсчлэлээр** үйлдвэр, худалдаа үйлчилгээ, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн тээврийн систем, дэд бүтцийн үүднээс судалдаг. Улаанбаатар хотыг гэр хороолол, орон сууц, түүх соёлын газар, засаг захиргаа, үйлдвэр гэсэн шинжээр хуваан авч болно. Хотын чиг үүргээр ангилсан бүсчлэлийг дараах байдлаар ангилсан. Орон сууц болон олон нийтийн бүс: нягтрал багатай, нам давхрын орон сууцны бүс; орон сууц ба олон нийтийн холимог бүс; нягтрал ихтэй өндөр давхрын орон сууцны бүс; хорооллын худалдааны бүс.

Үйлдвэрлэлийн бүс: үйлдвэрлэл орон сууцны холимог бүс, үйлдвэрлэлийн тусгай бүс.

Ногоон байгууламж, амралт жууцлалын бүс: ногоон ой, задгай орчны хамгаалалтын бүс; ногоон байгууламж, амралт, жууцлалын бүс (Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Нийслэлийн засаг даргын Тамгын газар, 2009).

**Оршин суугаа газрын шинжилгээ** - хот доторхи орон зайн байршлыг нийгмийн тэгш бүс байдлын үүднээс нийгэмд ямар байр суурь эзэлж байгаагаас хамаараад оршин суух байршил тодорхойлогдож байдаг. Оршин суугчдын амьдрах орчин, амьдралын нөхцөл, оршин суугчдын хүн ам зүйн шинж тэмдэг зэрэг нийгмийн тэгш бүс байдлын үзүүлэлтээр шинжилж болно.

**Хотын морфологи** - оршин суугчдын хотын талаарх төсөөллийг буюу хамгийн таатай, үнэ цэнэтэй газар, дүүрэг хорооллын нэр хүнд, бэлгэ тэмдгийн талаарх оршин суугчдын байр суурийг судалдаг. Хотын оршин суугчид хотын талаарх ямар үзэл бодолтой байгаа эсэх, хотыг чиг үүргийн хувьд ямар

бүсэд хувааж байгаа, өөрийн оршин суугаа газрын талаарх ямар ойлголт төсөөлөлтэй байгаа эсхийг морфологийн аргаар судалж болно.

### **Хотын сегрегацийн талаарх ойлголт**

Социологийн шинжлэх ухаанд хот доторхи нийгмийн бүлгүүд ямар нэгэн шинжээрээ орон зайн хувьд хуваарилагдахыг *сегрегаци* (лат. *segregacio* – тусгайлах, ялгах) гэдэг.

Энэхүү нэр томъёог анх Чикаго сургуулийн хотын экологийн хандлагын хүрээнд боловсруулж шинжлэх ухаан эргэлтэнд оруулсан. Сегрегаци гэдэг нь хотын газар нутагт оршин суугчид ямар нэгэн нийтлэг шинж тэмдэгтэй хотын нэг хэсэгт төвлөрсөн байдлаар оршин суухыг хэлнэ.

Хотын сегрегаци анх 1920-иод оноос судлаачдын анхааралд орсон. Түүнээс хойш сегрегацийг судлах олон хандлага, судалгааны арга зүй гаргасан боловч нэгдсэн судалгааны арга зүй гараагүй бөгөөд нэгдсэн тодорхойлолт ч байхгүй байдаг. Судлаачийн байр суурь болон судлаж буй объектоос хамаараад сегрегаци янз бүрийн шинж тэмдэг, хэлбэртэй байдаг. Сегрегаци сайн дурын эсвэл сайн дурын бус байж болно. Сайн дурын бус сегрегаци нь төрийн бодлогын үр дүн байж болно. Түүний дагуу хүн амын янз бүрийн бүлгүүд аливаа нэгэн газарт амьдрах эсвэл тодорхой цагт хотын аль нэгэн хэсэгт байх хэрэгтэй болдог. Легитим буюу албан ёсны сегрегаци хамгийн анхны хэлбэр гэж авч үзэж болно. Тухайлбал, Венецийн еврейчуудын гетто хороолол. Мөн дундад зууны үед Европын хотуудад гар урлалын суурин газрууд байршилж тэдгээр нь феодалын нийгмээс аж үйлдвэржсэн нийгэм рүү шилжиж эхэлсэнтэй холбоотой аажмаар бусад хороолуудтай холилсон. АНУ-ын өмнөд хэсгийн мужуудад хууль ёсны дагуу хуваах хамгийн түгээмэл хэлбэр бол нийтийн орон зай, үйлчилгээг тусгаарлах явдал байв. Тухайлбал, нийтийн тээвэрт цагаан ба хар арьстангуудыг өөр өөр хэсэгт суулгах дүрэмтэй байсан. Олон нийтийн бие засах газар, ундны усан оргилууруудыг арьсны өнгөөр нь хуваажээ. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад ижил төрлийн хэм хэмжээг арьсны өнгөөр ялгаварлан гадуурхахтай холбогдуулан хүмүүсийг оршин суугаа газраар хоёр хэсэгт хуваадаг байсан түүхтэй. АНУ-ын сегрегацийн талаарх бүтээлүүд голчлон арьс өнгөний ялгаварлан гадуурхалтын үүднээс авч үздэг. Учир нь Африк, Америк, цагаан арьстнуудын нийгэм дэх тэгш бус байр суурь нь тэднийг хот, захын болон хөдөө орон нутгийн янз бүрийн газарт суурьшихад хүргэсэн юм (Экономика, 2020).

Хотын сегрегацийг социологийн шинжлэх ухаанд дараах шинжээр ялгаж судалдаг.

**Үндэс угсаа** - Ялгаварлан гадуурхалтын туйлын хэлбэр, нийгмийн нэг хэсгийг нөгөө хэсгээс нь албадан шилжүүлэх бодлого, арьс өнгө ба үндэс угсааны шинжээр эрхийг нь хязгаарлах, тусгай газарт албадан суурьшуулах /гетто/. Жишээлбэл, Сталины засаглалын үед “найдваргүй” үндэстнүүдийг (Алс Дорнодод амьдарч буй солонгос ба хятадуудыг; баруун бүсд амьдарч буй польш, финны, германуудыг) болон “урвагч ард” гэж нэрлэгддэг (халимаг, карачаев, балкар, чечен, ингуш, Крымын татарууд) хүмүүсийг нутгаас нь албадан гаргасан. Тухайлбал, *650 мянган чеченийг Дэлхийн II дайны үед албадан гаргасан*.

**Арьс өнгө** - АНУ-д цагаан арьстнуудыг бусад үндэстний бүлгээс тусгайлах нь 1950-аад онд зарим мужид жирийн үзэгдэл байсан. Ихэвчлэн хар арьстнууд болон индианчуудаас тусгайлдаг байсан. Жишээ нь, *Автобусан дахь сегрегаци, АНУ, 1950-аад оны үе: эхний 4 эгнээнд дан цагаан арьстнууд, ард талын суудалд дан хар, өнгөт арьстнууд суудаг байсан. Цагаан арьстнууд автобусанд суугаагүй ч гэсэн эхний 4 эгнээнд хар, өнгөт арьстнууд сууж болохгүй байлаа*.

**Амьжиргааны түвшин** - хот доторхи байршил, дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгө болон газрын үнэ, дэлгүүр хоршоо, гэрэлтүүлэг, нийтийн тээврийн бүтэц гэх мэт шалтгаанаас хамаараад баячуудын, ядуусын, холимог хороолол бий болдог.

**Боловсролын түвшин** - гэр бүлийн орлого, үндэс угсаа, гэр бүлийн болон амьдарч буй орчин, хэл, шашин, соёлоос хамаарч хотын оршин суугчид ямар сургуульд сурах, ямар боловсрол эзэмших нь ялгаатай байдаг.

**Амьдрах орчин** - амьдрах орчинд мөн л гэр бүлийн орлого, үндэс угсаа, шашин, соёл ихээр нөлөөлдөг. Баячуудын хороолол, ядуусын хороолол нь амьдрах орчны хувьд эрс ялгаатай байдаг.

## Сегрегацийн үр дагавар ба ач холбогдол

Хотын сегрегаци нь тухайн хотын онцлог шинж чанараас хамааран өөр өөр байдлаар илэрч болох олон талт цогц үйл явц юм. Гэсэн хэдий ч хуваагдмал байдал нь хэд хэдэн эрсдэл, сөрөг үр дагаварыг дагуулдаг. Хотын сегрегацийн **эдийн засгийн** нөлөө нь ихэнх тохиолдолд хуваагдмал байдалд орсон бүлэгт сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, сегрегацид автагдсан хороололд ажлын байрны хомсдол үүсч орон нутгийн иргэд ажил эрхлэх боломж нь хязгаарлагдмал болдог. Тухайн хотын хэсгийн иргэдийн орлого нь доогуур, ажилгүйдлийн түвшин нь дээгүүр, боловсролын түвшин ч доогуур байдаг. Тиймээс сегрегацид автагдсан хотын хэсэг нь ядууралтай холбоотой гэсэн үг. Мөн сегреаци нь хүн амын нийгмийн мобил хөдөлгөөнийг багасгадаг.

Олон судлаачдын үзэж байгаагаар сегрегацийн **социаль** үр дагавар нь гэмт хэргийн өсөлт. Сегрегацийн хороололд гэмт хэргийн түвшин нэмэгдэх магадлал нь маш өндөр байдаг. Сэтгэл зүйн үр дагавар нь сегрегацийн хороололд амьдарч буй иргэд өөрийгөө тодорхойлох, бусад хүнтэй харьцуулахад бэрхшээлтэй тулгардаг. Улс төрийн үр нөлөө нь сегрегацийн хорооллын иргэд маргиналь бүлэгт хамрагдаж улс төрийн идэвхээс татгалзах магадлалтай аль эсвэл нэг талыг хэт их дэмжсэн, раикаль үзэл бодолтой болох магадлалтай юм. Яс үндэсний шинжээр хуваагдмал байдалтай иргэд үндэс угсаатан хоорондын зөрчилд өртөж нийтийн самууныг дагуулах эрсдэлтэй (Экономика, 2020).

Арьс өнгөөр хуваагдсан сегрегацийн хамгийн гол рүү дагавар нь нийгмийн туйлт байдал болдог. Энэ нь нийгмийн дунд ангийн төлөөлөгчдийн хүн амд эзлэх хувь нь багассаг бусад нийгмийн давхрагад (баячууд ба ядуучууд) шилжихийг хэлнэ. Ийнхүү үзэгдэл нь нийгэм-орн зайны хоёрдмол шинжтэй. Нэг талаас хотын орон зайд баян ба ядуусын хороолол гэж хуваагдана. Нөгөө талаар нийгэм нь өөрөө хуваагдмал шинжтэй болно: хүн амын ядуу хэсэг нь амьдралаа дээшлүүлэх боломжгүйгээс болоод боловсрол эзэмших, өндөр цалинтай ажлын байртай болох боломжгүй болно. Социаль хуваагдмал байдал нь сайн дурын ба сайн дурын бус харин шахалтын шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл, хотын иргэд төрийн бодлогын дагуу эсвэл өөрийн сонголтоор бус эдийн засгийн хөгжлийн үүднээс туйлын байдалд ордог байгаа. (Экономика, 2020).

## Хотжилтын үйл явц ба Монгол улс

Сүүлийн арваад жилд АНУ болон Европд нийгэм дэх тэгш бус байдлаас шинэ нийгмийн бүтцийн талаар бичиж, хэлэлцэж байна. Энэ нь урд өмнө байсан дорд үзэх болон ялгаварлан гадуурхах хэлбэртэй харьцуулахад өөр хэмжүүрээр хэмжигдэх болжээ. Үүнд хүн амын оршин суугчдын бүлгийн орон сууцны байршлын тэгш бус хуваарилалт болох тусгаарлалт буюу сегрегаци чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь ядуурал болон нийгмийн давхраажил нэмэгдэхийн зэрэгцээ *ялгаварлан гадуурхагдах* эсвэл *хотын социаль хуваагдал* гэсэн нэр томъёогоор нэрлэж болох нийгэм дэх тэгш бус байдлын шинэ бүтэц бий болж байгаатай холбоотой. Ялгаварлан гадуурхагдах гэдэг нь айл өрх эсвэл хувь хүмүүсийн амьдрах нөхцөл нийгмийн амьжиргааны дунд стандарттай харьцуулахад доройтох, эсвэл түүнээс ялгарахад хүргэж байгаа үйл явц юм. *Эдийн засгийн* талаас энэ хүмүүс болон айл өрхүүд нь хөдөлмөрийн зах зээлийн харилцаанд цаашид оролцох боломжгүй болсон, өөрөөр хэлбэл, ажил олох боломжгүй, албан *байгууллагуудтай* харилцахад улс төрийн болон төр, нийгмийн байгууллагууд нь даван туушгүй саад бэрхшээл болсон, амьдралын үндсэн нөхцөл болох *ахуй соёлын* талаар гадуурхагдаж, ялгаварлан үзэж байгаа нь өөрийгөө хүндэтгэх, ёс суртахуунаа алдахад хүргэх бөгөөд *нийгмийн* хувьд бүтнээр нь авч үзвэл нийгмийн дийлэнх хэсгээс тусгаарлагдаж, түүнтэй харилцах боломж хаагддаг. Хувь хүмүүс болон айл өрхүүд дээрх бүх дөрвөн хэмжүүрээр нийгмийн дундаж түвшингээс амьдралын түвшин нь ихээхэн доройтож ялгаварлан гадуурхагдах үйл явцын оргилд хүрэх бөгөөд үүнээс гадна нийгмээс тэд “өөрөө салж байгаатайгаа эвлэрэх” явдалтай давхцвал урам хугарсан, хөндий хүйтэн болон ухрах байдлаар туйлын цэг нь илэрнэ. Энэ хохирогчид нь үүнээс болж нийгмээс ямар нэг зүйлийг хүлээхээ больж, хайхрамжгүй, цөхөрсөн байдалтай болдог. (H.Naussermann, 2011) Өөрөөр хэлбэл, тус дөрвөн хэмжүүрийн дагуу хүмүүс болон айл өрхүүд нийгмийн системүүдээс хэрхэн хаагдмал байдалд орж байгааг ажиглаж болох юм.

“Хотын сегрегаци өрхүүдийн оршин суух газрын тодорхой хуваарилалтын үндсэн дээр бий болсоноор орлого, боловсрол ба амьдралын хэв маягийн ялгаан дээр үндэслэсэн нийгмийн тэгш бус байдал нь орон зайных болж хувирна. Ингэснээр нийгмийн орон зайн сегрегацийн судалгаа оршин суух газрын сонголтыг судалдаг бөгөөд бий болсон оршин суух газрын хуваарилалтаар загварыг нь тайлбарладаг.” (J.Weidenholzer, H. Stoger, 2013) Сегрегаци буюу хуваагдмал байдал нь нь сайн дурын эсвэл албан хүчээр тулгагдах байдлаар илэрнэ. Үүнд айл өрхийн хөрөнгө мөнгөний эх үүсвэр их байх тусам оршин суух байршлаа сонгоход бэрхшээл багатай байх бөгөөд дураараа шийдвэр гаргана. Харин материаллаг, нийгмийн болон соёл ахуйн хувьд хөрөнгө, эх үүсвэр багатай тохиолдолд сонголт хийх боломж бага байдаг болохоор орон сууцны зах зээлийн ихэнхи сегментүүд нь тэдэнд хаалттай байдаг. Материаллаг саад бэрхшээл болон нийгэм, соёлын хувьд гадуурхагдах нь хүн амыг нийгэмдээ ялгахад нь хүргэдэг. Хамгийн баян болон хамгийн ядуу хүмүүсийн хооронд ерөнхийдөө хамгийн хүчтэй сегрегаци үүсдэг. Үүнд баячууд нь хүссэн газарт, ядуучууд нь ноогдсон газарт л амьдарна.

Улаанбаатар хотын хотжилтын хүрээнд сегрегацийг судлахад шилжих хөдөлгөөний учир шалтгаан, түүний хүчин зүлсийг судлах шаардлагатай. Хүмүүс яагаад оршин суугаа газраа орхиж шилжих хөдөлгөөнд оролцдог вэ? Шилжих хөдөлгөөний шалтгаан нь хүний амьдралтай шууд холбоотой, сайн сайхан амьдрах эрэлхийлэл болдог. Өөрөөр хэлбэл, шилжих хөдөлгөөн нь амьжиргаагаа дээшлүүлэх стратеги юм. Рахмато, Корветт, Агарвал нарын судлаачдын гаргасан ангиллын дагуу хүн төрлөхтний амьдрал ахуйгаа дээшлүүлэх арга замыг тодорхойлоход юуны өмнө хэмнэхтэй холбоотой. Хэмнэх гэдэг нь аль болгоно өртөг багатай бүтээгдэхүүн хэрэглэх, хэрэглээний зардлаа бууруулах арга зам. Хоёрдугаарт, хуримтлал бий болгох арга. Үүнд эд зүйлс хуримтлуулах, хадгалах замаар амьжиргаагаа хэвийн авч явах боломж бүрдэнэ. Гуравдугаарт, өргөжүүлэх буюу амьжиргааны хувьд тохиолдож буй эрсдэлээс хамгаалах, орлогоо нэмэгдүүлэх, орлогын хэд хэдэн үүсвэртэй болох, үүгээр амьжиргааны баталгаат байдал бий болгох. Шилжих хөдөлгөөний дөрөв дэх арга нь байгууллагаас хууль ёсны тэтгэмж авах, хамаатан садан, найз нөхдөөс материаллаг ба материаллаг бус дэмжлэг хүртэх нь бас амьжиргааны арга зам юм. Сүүлийн арга зам нь шилжих хөдөлгөөнд оролцох. Үүнд орлого олох, зах зээлд ойртох, үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээгээ өргөжүүлэх нөхцөл сайтай нутаг, улс орон руу шилжин суурьших замаар амьжиргаагаа дээшлүүлэх боломжтой болдог (J.Weidenholzer, H. Stoger, 2013)

Улаанбаатар хотын 2020 оны ядуурлын түвшин нь 26.5 хувийг эзэлж байгаа бөгөөд шилжин ирсэн иргэд ядуучуудын эгнээг эзэлж байна. Тэд ядуурлын эх сурвалж бөгөөд хотын зах руугаа тэлсэний гол шалтгаан хэмээн хотын оршин суугчдын зүгээс ихэвчлэн дорд үзэн гадуурхдаг боловч тус тайлангийн хүрээнд цуглуулсан тоон болон этнографик судалгааны баримт мэдээллээс харахад эдгээр үзэл санаа нотлогдохгүй байна. Дэлхийн Банкны 2014 оны судалгааны дүгнэлт нь шилжин ирсэн иргэд бүхэлдээ орлогын хувьд хотын ядуу иргэдийн тоонд багтахгүй болохыг харуулж байна. Нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал, Улаанбаатар хотын оршин суугаа байршил зэргээр харьцуулан орлогын ядуурлыг тодорхойлох шугаман регрессийн загвараас харахад шилжин ирсэн байдал ба орлого хоёрын хооронд тодорхой хэмжээний хамаарал байхгүй байна. Нийгмийн тодорхой бүлгүүд өөрсдийн онцлог ухамсар (identity) буюу нийгмийн нөхцөл байдлаасаа шалтгаалан таагүй нөхцөл байдалд оршин байдаг. Уг таагүй нөхцөл байдал нь нийгмээс гутаан доромжлох (social stigma) хэлбэрээр илэрхийлэгддэг ба нийгмийн гадуурхал болон өртөмхий байдлыг бий болгоход гол хүчин зүйл болдог.

Шилжин ирсэн иргэд нь орлогын хувьд ядуу биш байгаа боловч шилжин ирсэн айл өрхийн 60% олон хэмжээст ядуу байхад шилжин ирээгүй айл өрхийн хувьд 48% ийм байгаа нь шилжин ирсэн өрхийн ихээхэн хувь гэр хороолол буюу үйлчилгээгүй нөхцөлд оршин сууж байгаатай холбоотой. Улаанбаатар хотод нүүн ирэгсдийн дийлэнх хувь гэр хороололд амьдардаг хэдий ч нийтлэг ойлголтын дагуу захын гэр хороололд төвлөрөөгүй байсан ба гэр хорооллын байршил тус бүрээр тархан амьдардаг.

#### **Дүгнэлт**

Хотжилт бол XXI зууны хамгийн чухал хөгжлийн хандлага. 2021 оны байдлаар нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувь нь 56 хувь хүртэл өссөн байна. Ковид 19 цар тахал хотжилтын үйл явцыг бараг зэрэг удаашруулсан боловч одоогийн байдлаар хотжилт өмнөх шиг маш эрчимтэй явагдаж байна. 2050 онд энэхүү тоо 68 хувь хүрэх магадлалтай байна.

Хотын социологийн хөгжил нь Барууны эрдэмтдтэй зайлшгүй холбоотой бөгөөд хотын судалгааны олон, арга зүйн үдсийг АНУ-ын Чикаго хотын Чикаго сургууль хэмээх школын төлөөлөгчид тавьсан. Чикаго хотын хөгжлийн түүхээс харахад Европын орнуудаас шилжин ирсэн хүмүүс хоорондоо үндэс угсаа, хэл, арьс өнгө, амьдралын хэв маяг, сол зэрэг шинжээр тод ялгарч хотын хуваагдмал байдал үүсэж түүнийг хотын сегрегаци гэж нэрлэсэн. Хотын сегрегацийг Монгол улсын жишээн дээр авч үзэхэд хотын түүх, үүсэл, хөгжил, нийгэм эдийн засгийн байдлыг авч үзэх шаардлагатай. Монгол улсад 1990 оноос хойш эдийн засгийн хүчин зүйл, үнэт зүйлс ихээхэн ач холбогдолтой болсны улмаас орлого, баялаг, эд хөрөнгө, өмч, боловсролын түвшин, нас зэрэг шинж тэмдгээр хотын сегрегацийг судлах нь зүйтэй гэж үзэж байна. Өөр нэгэн судлах зүйл бол оршин суугаа газар оршин суугчдад хэрхэн нөлөөлж байна, энэ нь оршин суугчдын төсөөлөлд хэрхэн нөлөөлж байгааг судлах шаардлагатай байна.

### **Ашигласан материал:**

1. H.Haussermann. (2011). *Wohnen und Quartier: Ursachen sozialraumlicher segregation* (Б. XXVI ). (H.Haussermann, Хян.) Wiesbaden: ФСЭХ, Философи, эрх зүйн судлал.
2. J.Weidenholzer, H. Stoger. (2013). Auf dem Weg zur desintegrierten Stadt? – Zum Problem der sozialraeumlichen Segregation in Europa. *Эрдмийн ертөнц*, 38.
3. Simmel, G. (1903). *Die Grossstaedte und das Gesitesleben*. Dresden. <https://www.europa.clio-online.de/quelle/id/q63-28252> -ээс Гаргасан
4. UN. (2008). *World Urbanization Prospects: The 2007 Revision. Highlights*. New York.
5. Одриосола, М. (2014). Эволюция социологических теорий города XIX-XX вв. *Научный потенциал: Работы молодых ученых*, 2. <https://cyberleninka.ru/article/n/evolyutsiya-sotsiologicheskikh-teoriy-goroda-xix-xx-vv-ээс>
6. ФСЭЗХ. (2012). *Хотын социологи: онол, арга зүй*. УБ: Тод бичиг.
7. ШУА, Ф. (2014). *Монгол дахь хотжилт: үйл явц ба төлөв байдал*. УБ: Тод бичиг.
8. Экономика, и. (2020). Разработка концепции и методологии изучения внутригородской социально-пространственной сегрегации в российских городах. [http://www.urbanomics.ru/sites/default/files/razrabotka\\_konceptcii\\_i\\_metodologii\\_izucheniya\\_vnutri\\_gorodskoy\\_socialno-prostranstvennoy\\_segregacii\\_v\\_rossiyskih\\_gorodah.pdf](http://www.urbanomics.ru/sites/default/files/razrabotka_konceptcii_i_metodologii_izucheniya_vnutri_gorodskoy_socialno-prostranstvennoy_segregacii_v_rossiyskih_gorodah.pdf)-ээс
9. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Нийслэлийн засаг даргын Тамгын газар. (2009). *Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөрийн судалгаа*. Улаанбаатар.